

Чингис хааныг хэн хэдийд, хэрхэн,  
үнэлж ирсэн тухайд

Доктор /PhD/, профессор Ц.Жамбалсүрэн

Олон мянган жилийн түүхтэй монгол түмний эв нэгдлийг хангаж, нэгдсэн улс байгуулахын төлөө чин зориг гарган зүтгэж, Монгол улс, Монголын ард түмний өмнө мөнхийн гавъяа байгуулсан эзэн богд Чингис хааныг Төв Азийн малчин нүүдэлчид, эсгий туургатнууд найман зуун жилийн турш оройн дээд шүтээнээ болгож, төр улсынхаа тусгаар тогтнолын билэг тэмдэг гэж үзэж дээдлэн хүндэтгэж ирснийг түүх бэлээхэн гэрчилж байна. Цаг цагаараа байдаггүй гэгчээр энэ хүндэтгэл бишрэл нэгэн үе дэврэн оргилж, нэгэн үе хязгаарлагдан нууцлагдаж, дахин сэргэн гарч ирэх зэргээр монголчуудын сэтгэл зүрхэнд олон үеийн турш үлдэх нь эргэлзээгүй санагдана.

Эзэн богд Чингисээс Лигдэн хааныг хүртэл Монголын тулгар төрийг алтан ургийнхан үе залгамжлан барьсан олон зуун жилд Чингис хаан төр улсын сүр хүчний туг сүлд нь болж байв. Монгол улс нэгэн үе доройтон бусдын эрхэнд орсон манжийн ноёрхлын жилүүдэд монголчуудын дунд их хааны гэгээн дүр амилан тусгаар тогтнолын төлөө тэмцлийн нь туг болохоос манж нар айн болгоомжилж байжээ. Цагтаа Хятад, Алтан улсыг өвдөг сөгдүүлж байсан монголчууд Чингис хааны тухай энэ үед зориглон өндөр дуугаар ярьж чадаагүй ч ном, бичиг судартаа магтан дуулсаар иржээ. 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ялж, тусгаар тогтносон Богд Хаант улсаа байгуулсан энэ жилүүдэд Чингис хааныг өргөмжлөн магтах нь чөлөөтэй болж, түүний удмынхан хаан ширээний төлөө өрсөлдөж байсан боловч, удалгүй Монгол орон Хятадын гамин, Оросын цагаан цэргийн дарангуйлалд орсноор их эзэн Чингисийн тухай ярих нэгэн үе намджээ.

1921 онд Монгол орон үндэсний тусгаар тогтнолоо байлдан олж, эрх чөлөө, нийгмийн дэвшлийн замд оров. Энэ зам тун ээдрээтэй төвөг бэрхшээлтэй зам байлаа. Түүхэн нөхцөл байдлын улмаас, тусгаар тогтнолоо олж авах, хадгалан үлдэх эрх ашгийн үүднээс манай орон Зөвлөлт Орос улсыг түших, үнэнч холбоотны ёсоор харилцан бие биенээ дэмжин туслах замаар, урьд аль ч орон замнаж байгаагүй “нийгэм журмын” гэх замаар гар гараасаа хөтлөлцөн урагшлав. Дэлхийн хамгийн том 3 гүрний нэгтэй бат нягт холбоо тогтоосон нь “жигжиг” Монголын хувьд том ололт байлаа. Энэ нь хатуу зохион байгуулалттай, нэг үзэл суртал, нэг намын удирдлагыг бишрэн дагадаг, нийгмийн өөр байгуулалт бүхий капитализмтай сөргөлдөн оршдог учраас энэ системийн орнууд нэг нэгэнтэйгээ эв санааны ган бат нэгдэлтэй байх пролетарийн интернациональч үзлийг оройн дээд манлай болгосон байх хатуу хуультай нийгэм байсан билээ.

1930-аад оны сүүлч, дөчөөд оны дунд үед олон улсын байдал нэн хурцдаж, дэлхийн дайн шатлан өргөжиж, Монгол-Зөвлөлтийн цэрэг Халхын голд Японы милитаристуудыг бут цохиж, фашизмын эсрэг Зөвлөлтийн ард түмний тэмцлийг монголчууд тууштай дэмжин, 1945 онд Японыг бут цохих дайнд хамтран оролцов. Энэ үед залуу үе, нийт хөдөлмөрчдийг цэрэг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, Монголын цэргийн өв уламжлалыг сэргээх талаар нам, төр тухайн үед ихээхэн анхаарч байжээ. Үүний зүй ёсны үр дүн болж Чингисийн цэргийн урлаг, жанжны чадвар, жолоодогчийн аугаа их ур ухааныг сэргээн санах, бичиж, ярилцах явдал нэмэгдэж, түүний түүхэнд гүйцэтгэсэн үүргийг эерэг талаас нь магтах хандлага нэг үе хүчтэй болж, энэ хандлагыг тодорхой хэмжээгээр “хазаарлан барих” шаардлага ч тэр үед гарсан бололтой.

Энэ үед социализм, марксизм-ленинизмийн гол онолч гэгдэж, аугаа ЗХУ-ын удирдагч байсан, генералиссмус И.В.Сталин бичихдээ: “Түүхийн шинжлэх ухаан жинхэнэ шинжлэх ухаан байхыг хүсвэл нийгмийн хөгжлийн түүхийг хаад болон цэргийн үйл ажиллагаа, улсуудыг “байлдан эзлэгчид ба дагуулагчдын” ажиллагаанд аваачихгүй, харин материал баялаг үйлдвэрлэгчдийн түүх, хөдөлмөрчин нийтийн түүх, ард түмний түүхийг юуны урьд судлан голловол зохино” хэмээн “лүндэн” буулгасан нь бараг л

Чингис хааны үр удам-монголчуудад хандан хэлсэн мэт ойлгогдож байсан төдийгүй энэ маягаар Чингисийн асуудалд хандахыг тулгасан хэрэг мөн байлаа.

1949 онд Монголын хэсэг сэхээтнүүд “Ардын унших бичиг” гэдэг нэгэн сурах бичиг бичиж нийтлүүлжээ. Уг ном монголын түүхийн олон асуудалд бодитой хандаж чадаагүй, монголын тэр үеийн нам, төрийн зүтгэлтнүүдийг хэт магтан дөвийлгөсөн, онол, бодлогын хувьд тааруухан сурах болжээ. 1949 оны III сарын 10-нд МАХН-ын ТХ-ы Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал УТТ-ы гишүүдэд бичсэн захидлаас үзэхэд: “Энэхүү номд миний хувийн түүх хэвлэгдсэн байхыг би гэнэт мэдэв. Ичгүүргүй бялдуучлалаар нэвтэрсэн энэ долигонуур бичиг миний уур жигшлийг хичнээн хүргэснийг би хэлж чадахгүй байна. Энэхүү бүтээл дотор Цэдэнбалын нэрийг ихэд магтаж мандуулсан учир түүний мөр бүр миний уур зэвүүг хүргэв. Энэхүү бичиг нь эхнээсээ аваад дуустал “товойж”, “тодорч”, “талархлыг биедээ татаж чадсан”, “бишрүүлж”, “онц хурц ухааныг гэрэлтүүлэн”, “удирдах явдлаар гайхагдаж”, “гайхамшигт сайнаар шинжлэх ухааныг холбон хэрэглэж”, “өндөр гавъяануудыг байгуулав” гэх зэрэг Цэдэнбалыг магтсан бөгөөд байж үл болох, үл зохилдох гоё үг магтаалаар дүүрсэн ... Удирдах ажилтан бүрийг “жолоодогч”, “хүндэт удирдагч” болгоод байх нь зохихгүй. Энэ мөрүүдийг уншихад миний царай улайж, биед эвгүй санагдаж байна. Үүнийг бялдуучлал, зулгуйдал мөн бөгөөд бас зохиогч, редактор ба хэвлэгсдийн маш хариуцлагагүйг харуулж байна гэхээс өөрөөр үнэлж болохгүй байна ... Ерөнхийдөө энэхүү ном нь маш муу бичигдсэн бөгөөд улс төрийн талаар ихээхэн алдаатай байна” гэж өөрийг нь хэт магтсаны төлөө тэрхүү номыг хатуухан шүүмжилсэн аж.

Хэрэг цааш нь мандаж уг номыг олон талаас нь шүүн хэлэлцжээ. Ю.Цэдэнбалыг эх толгойгүй магтсан номын зохиогчид эзэн Чингис хаанаа мэдээжээр бүр ч сайн өргөмжлөн бичээд авчээ. Тэр үеийн намын удирдагчид нэг хүний рольд иймэрхүү маягаар хандах нь олон улсын болон улс төр, үзэл суртлын тухайн үеийн өвөрмөц нөхцөлтэй тохирохгүй байна гэж үзэцгээжээ.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо “Ардын унших бичгийн тухай” /1949.7.21./ тогтоолдоо “Энэ номын дотор Монголын феодализмын тухай бичсэн түүхийн хэсэгт Чингис хаанаас явуулж байсан дээрмийн аян дайнд ангийн чанартай марксист үнэлэлтийг өгөөгүйгээр барахгүй, харин түүний үйл явдлыг магтсан зүйл ч байна. Энэ явдал манай сэхээтний хоцрогдонгүй зарим хэсгийн дотор үндэсний явцуу үзэл шигдэн оршиж байгаагийн тусгал мөн” хэмээн зааснаас үзэхэд Чингис хааны эерэг талыг магтан дуулах явдалд ямар нэгэн хэмжээгээр “тормоз” хийж эхэлжээ.

Улс Төрийн Товчоо мөн онд “БНМАУ-ын түүх ба утга зохиолыг сургуулиудад зааж байгаа байдлын тухай” шинэ тогтоол гаргаж хэд хэдэн хүний нэр заан шүүмжилжээ. Үүнд: Х.Пэрлээ “Чингис хааны ролийн тухай огт шинжлэх ухаанч бус дүгнэлт гаргаж ... түүнийг дарангуйлагчид ба гадаадын байлдан дагуулагчдын эсрэг тэмцэгч, хөдөлмөрчдийн жолоодогч, эх оронч” гэж үзүүлсэн байна. Д.Содном “Чингис хааны үед Монголын соёл хамгийн дээд хөгжилдөө хүрсэн бөгөөд Чингис хаан үлэмж соёлт суурин улс үндэстнийг довтолсон аян дайн бол Монголын ард түмний “алтан үе” байсан мэтээр үзүүлсэн дүгнэлт гаргасан”, Ш.Нацагдорж, Л.Дүгэрсүрэн өөрийн бүтээлдээ “Чингис хааны булаан эзлэх харгис бодлогыг бүрхэгдүүлжээ. Тэр үед ард олон нь феодалуудад хатуу ширүүнээр мөлжигдөж газар нутгийг эзлэх, хүн ардыг хүйс тэмтрэн хядах ба соёл боловсролыг нь бүрэлгэн устгахад чиглэсэн Чингис хааны түрэмгий дайны шинж чанарын тухай дув дуугүй дарж өнгөрөөх явдал одоо хүртэл үргэлжилсээр байна” гээд манай ардын хувьсгалт намын зарчим болсон пролетарийн интернационализмын зарчмын шууд эсрэг хандсан хөрөнгөтний националист үзэл одоо хүртэл бугшин оршоор байгааг эдгээр бүх баримт үзүүлж байна” гэж дүгнэжээ.

Түүхийн нэгэн үед Чингис хааны хүү Зүчийн удирдсан их талын эрэлхэг баатрууд хуучин ЗХУ-ын ард түмнүүдийн эртний өвөг дээдсийн нутаг дээр 1243 оноос Алтан Орд хэмээх хүчирхэг гүрнийг байгуулан тунхаглаж, түүний сүүлчийн хаан Ахмед 1481 онд таалал төгсөж Алтан Орд улс бүрэн унасан гэж үзэхэд 240 жил Монгол, Оросын ард түмний хувь заяа ойр дотно байсан аж.. Түүхийн хүрд эргэдгээрээ эргэж, Оросын ард

түмэн XIX, XX зуунд Их Орос, ЗХУ гэх аугаа их гүрнийг байгуулж чадсан бөгөөд энэ үеийн Их Оросын үндэсний үзлийн үүднээс, Чингис хаан, түүний үр ач нарын байлдан дагуулалтыг сөргөөр үзэж дүгнэж байсан нь хэн ч бодсон тодорхой билээ. Гэтэл XIX-XX зууны зааг үед эдийн засаг нь тартагтаа хүртэл доройтсон, Манж гүрний алс бөглүү колони байсан, хагас сая хүнтэй Монголчууд хөрш зэргэлдээ Орос орны сайн санаат хүмүүсийн дэмжлэгээр 1921 онд эрх чөлөө тусгаар тогтнолоо олж, 1939, 1945 онд Зөвлөлт-Монголын нийтлэг эрх ашгийн төлөө хамтран тэмцэж, ялж дийлж байжээ. Улс орныхоо нийгэм-эдийн засгийн хоцрогдлыг давж хөгжин дэвшихэд хөрш их гүрний хөрөнгө оруулалт, ивээн тэтгэх ажиллагаа нэн чухал байсан үед Орос Зөвлөлтийн хүмүүсийн эрх ашиг, үндэсний ухамсар, бодол санааг хүндэтгэн үзэх, бодлогоо зохицуулан уялдуулахаас өөр арга зам байгаагүй учраас Чингис хааныг үнэлэн дүгнэх асуудалд аргагүй буулт хийж байжээ. Аугаа их хөрш гүрний "хөлд нь суух", уян хатан, эв эв хичээсэн, найрсаг прагматик бодлого л тэр үед Монголыг аврах тийм түүхэн нөхцөл бий болоод байв.

Дэлхийн дайн дуусаад удаагүй байсан тухайн үед эв нэгдэл, энх тайвны үзэл санаа хүч авч, дайн, аливаа түрэмгийлэгчдийг үзэн ядах үзэл дэлхий даяар нэн хүчтэй байсан үед Наполеон, Гитлер нарын зэрэг байлдан дагуулагчдын дээдлэн хүндэтгэж, жишээ авдаг байсан Чингис хааны ролийг үнэлэх асуудалд болгоомжтой хандсан, Улс төрийн Товчоог толгойлж байсан Ю.Цэдэнбал, гишүүн Г.Бумцэнд, Х.Чойбалсан, С.Янжмаа, Д.Дамба, Ч.Сүрэнжав, Б.Ширэндэв нарын шийдвэрийг ойлгож болох талтай ч дээрхи тогтоолууд нь Чингис хааны талаар өөдтэйгээр ярих явдлыг буруушаасан, монголчуудын үндэсний аливаа үзэл сэргэх явдалд цохилт болсон бүхэлдээ алдаатай шийдвэр байсан юм. Хожим нь 1962 онд Улс төрийн Товчоо, Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тэмдэглэх тухай асуудал хэлэлцэх үед Ю.Цэдэнбал: "1949 оны тогтоол алдаатай байсныг дурдах нь зүйтэй... урьдах тогтоолд зохих засвар оруулахыг суртлын хэлтэст даалгах нь зүйтэй" гэж хоёр удаа сануулж хэлж байжээ.

Тавиад оны дунд үеэр олон улсын байдалд их өөрчлөлт гарч, Зөвлөлтийн удирдагч И.В.Сталин насан өөд болж, түүний хамт эрчийг нь хэт чангалсан коммунист үзэл суртал ямар нэг хэмжээгээр суларч, Сталиныг тахин шүтэхийн эсрэг тэмцэл ЗХУ-д өрнөж, Европын социалист орнуудад капитализм руу тэмүүлэх, социализмыг шүүмжлэх хандлага нэмэгдэж, социализмын орнуудын эв нэгдэл, коммунист хөдөлгөөний нэгдэл нягтрал шинэ сорилттой тулгарсан үе байв. Энэ нь мэдээж монголын нийгмийн амьдралд нөлөөлж, тухайн нийгмийн зарим шинж, нам, төрийн бодлогыг шүүмжлэх, шинэ амьдралыг эрэн тэмүүлэх хандлага хүчтэй болжээ. Энэхүү өргөн шүүмжлэлийн дотор "Эх орны бахархал болох үндэсний зүйлийг орхигдуулж байна. Ер нь монголын үндэсний юм бүхнийг феодалын гэж хэтрүүлэн харах хандлага байна. "Энэ бол буруу" Дангаасүрэн ЭТХ/; "48 оноос үндэсний үзэлтнийг буруушааснаас хойш Чингис зэрэг хүмүүсийн тухай дурьдахаа больсон. Дурдахаас айдаг байна. Энэ тогтоолыг эргэж харж баймаар юм" /Чойжил,ЭТХ/; "Бидэнд үндэсний юм болгох бахархал алга. Манайд тийм ийм юм байсан гэж хэлэхээр националист гэж хэлдэг. Эх орноо судлахаас өөр эрхэм үүрэг байхгүй. Сургуулиудад эх орны түүхийг заахгүй байна". /Сэнгэдорж Багшийн дээд сургууль/ гэх зэргээр ярилцаж, санал дэвшүүлэх болжээ.

Тэр үед МАХН-ыг удирдаж байсан Д.Дамба, тухайн асуудлыг гардан хариуцаж байсан Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Н.Лхамсүрэн, Ц.Дүгэрсүрэн, Д.Самдан нар монголын тэргүүлэх сэхээтэн нарын зөв зүйтэй шүүмжлэл санал бодолд зарчимчаар хандахын оронд бүхэлд нь манай сэхээтний эргэн төөрөлдөж буй хэрэг гэж үзэж 1956 онд "Манай намын бодлогод харш үзэл санаа үг, өгүүлэл гарч байгаа тухай" нууц тогтоол гаргаж эрс буруушаасан нь сэхээтний бүтээлч сэтгэлгээний өсөлтөд том лантуу болсон байна. Чингис хаантай холбоотой асуудлын тухайд үзэхэд чухамхүү яг энэ үед ЗХУКН болон нийт коммунист хөдөлгөөнд нэг хүнийг тахин шүтэх явдалтай тэмцэх их компани өхөлж, манайд маршал Чойбалсанг тахин шүтэж байсныг буруушаасан өргөн шүүмжлэл өрнөж байсан үед Чингисийг тахин шүтэх явдал бий болж даамжрахаас хувьсгалт намын удирдлага хаширлан цэрвэж байсныг зөв ойлгоход хэцүү

биш юм. Түүнээс гадна Зөвлөлтийн удирдагч байсан И.В.Сталин цэргийн зүтгэлтэн хүний хувьд Чингисийг бишрэн хүндэтгэдэг, түүнчлэн монголчуудыг Чингисийн удмынхан гэж үздэгийг бараг дэлхий мэдэж байхад Сталиныг шүүмжилсэн нь Чингисийг магтахаас айн болгоомжлох нэг үндэс болсон билээ.

Ийм үзэл хандлага улс төрийн хүрээнийхний төдийгүй шинжлэх ухааны зүтгэлтнүүдийн дунд ч байсан билээ. Монголын шинжлэх ухааны хүрээлэнгийн орлогч дарга, манай улсын анхны доктор, шинжлэх ухааны нэрт манай зүтгэлтэн Н.Жагварал 1950 онд “Шинжлэх ухаан” сэтгүүлд бичсэн өгүүлэлдээ: Манай сэхээтний зарим хэсэг “Монголын түүхийг зөвхөн Чингис тэргүүтэй хаадын байлдан дагууллын түүх болгож, Монголын ард түмний бүтээлч түүхэн ролийг үгүйсгэж байна”, “Чингис болон түүний дараах байлдан дагуулал бол Монголын ард түмний шим шүүсийг сорж, түүнийг дайны талбар дээр сөнөөж, улс орны эдийн засгийн хөгжлийг боож байсан. Гэтэл манай зарим хүмүүс Чингисийн булаан эзлэх явдал Монголын эдийн засгийг хөгжүүлж, Монголын түүхэнд их дэвшилттэй роль гүйцэтгэсэн мэтээр бичиж байна”, “Чингис ба түүний залгамжлагчдыг манай ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө “халуун амь бүлээн цусаа зориулсан” “аугаа их эх орончид” байсан мэтээр бичиж байна” гээд “Чингис хааныхан монголын ард түмний эрх ашгийн эсрэг шудрага бус дайн хийж байсан”<sup>1</sup> гэх мэтээр бичсэн байна. Дэлхийн хэмжээний аугаа том бие хүний үйл ажиллагааг дэлхийн болон монголын эрдэмтэд олон талаас нь үнэлж дүгнэж байлаа.

Тэр үеийн Монголын удирдагч Ю.Цэдэнбал 1956-1958 оны үед хамаарагдах өдрийн тэмдэглэлдээ энэ асуудлыг бичихдээ: “Үндсэрхэг үзэлтнүүд Чингис хааны ролийг бууруулахыг хүсч байна гэж ярьдаг. Чингис хаан бол бие хүний хувьд гарамгай авъяас чадвартай хүн байсан гэдгийг хэлэх хэрэгтэй. Удирдан явуулсан дайнаараа өөрийнхөө үеийн авъяаслаг жанжин гэдгийг харуулсан юм. Гэхдээ энэ нь хувийн авъяас чадлыг нь иш үндэс болгон Чингисийг болон түүний хийсэн дээрмийн дайныг өргөмжлөн магтаад бай гэсэн үг үү? үгүй, Монголын ард түмнийг нэгтгэхэд тэр дэвшилт үүрэг гүйцэтгэсэн нь маргаангүй. Гэхдээ тэд Ази, Европын ард түмний эсрэг дээрмийн дайн хийснээрээ харгис үүрэг гүйцэтгэсэн юм.” /Гэрэл сүүдэр: Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс/ гэж бичиж байжээ.

Ер нь эрдэмтэн, судлаач, аль эсвэл зохиолч, сэтгүүлч нар, эсвэл жирийн иргэн аль нэг асуудлаар хувийн санал бодлоо илэрхийлэх нэг хэрэг, улс орны нам, төр, засгийн удирдагчийн хувьд Ю.Цэдэнбал, Д.Дамба нарын хэлэх үг олон талаас нь цэгнэсэн, бодит үнэнтэй нийцсэн, сэтгэлийн хөөрөлд автагдаагүй, зөвхөн өөрийн улс орны хүрээнд биш, дэлхий нийт, олон улсын хэмжээнд сэтгэсэн, ямар ч нөхцөлд аль ч талаас нь авч үзэхэд үндэсний эрх ашиг болон ойр зэргэлдээ орны ард түмний эрх ашигтай зөрчилдөөгүй байх ёстой нь хүн бүхэнд ойлгомжтой бөгөөд энэ утгаар эвч үзвэл аливаа асуудлыг учир утгагүй хараар будах, аль эсвэл нүдээ аньж хоосон магтахын хоёр талтай туйлшралд авталгүй үнэнийг үнэнээр нь хэлсний хувьд Ю.Цэдэнбалын дээрх дүгнэлт зөв байсан гэж хэлж болмоор. Х.Чойбалсангийн итгэлтэй залгамжлагч байж, төрийн урьдын удирдагчаа, төрт ёсоо эрхэмлэн хүндэтгэхийн зэрэгцээ түүний алдааг ухаалгаар шүүмжлэх, нэг хүнийг тахин шүтэх бурангуй ёсны эсрэг тууштай бөгөөд учиртай начиртай тэмцэл явуулж байсан Ю.Цэдэнбал эрт цагийн төрийн зүтгэлтнийг өргөмжлөн гаргаж ирээд тахин шүтэх нь цаг нь болоогүй асуудал гэж үзэж байсан бололтой. Түүнчлэн нэг хүний ролийг магтан дуулснаар Монголын гадаад түшиг-аварга том гүрэнтэй харилцах монголчуудын уламжлалт сайхан харилцааг сэвтүүлэхээс болгоомжилж байсан хэрэг аж.

Гэтэл хүн хүний үзэл бодол янз янз байдаг болохоор коммунист үзэл суртлын хэмжээлшгүй ноёрхлын үед интернациональч үзлээр гагнагдсан социалист системийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байсан бага буурай орны удирдагч Ю.Цэдэнбалын “зовлон”-г ойлгодоггүй, Чингис хааны талаар баримталж байсан цаанатай наанатай дээрх байр суурийг зад шүүмжилдэг тийм санаа нийгэмд оршсоор ирсэн юм. Академич

<sup>1</sup> Нямын Жагварал. УБ., 2000, с.75.

Ш.Нацагдорж "Чингис хааны цадиг" хэмээх дорвитой бүтээлийнхээ дотор гурван хэсэг газар дахин дахин давтаж бичсэнээс үзэхэд "Манай улсын эрхийг монголын ямар ч хаанаас илүү олон жил эзэрхэн барьсан Ю.Цэдэнбал бол бидний өвөг дээдэс, тухайлбал Чингис хааныг элдвээр өрөөсгөлөөр хараан зүхэж, түүхэнд гүйцэтгэх эерэг ролийг бүрмөсөн үгүйсгэж, түүнийг зөвхөн цуст байлдан дагуулагч, яргачин байсан мэтээр батлахыг оролдож ... 1962 онд Чингисийн 800 жилийн ойг тэмдэглэв хэмээн Ю.Цэдэнбал аянга цахилгаан буулган Тэмүүжинг цуст яргачин гэж зүхэн харааж байв ... Миний бие энэ хөшөөг босгох ёслолд оролцож чадаагүй. Ю.Цэдэнбалын ниргэлтийн дараа тэнд очих нь битгий хэл зүглэхээс айж байлаа" гэжээ. /Чингис хааны цадиг/. Эзэн Чингисийн монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг эерэгээр үнэлсэн төрийн тэргүүнийхээ хэлсэн үгнүүдийг сайхь эрдэмтэн огт дурьдсангүй, "цуст яргачин" гэж хаана, хэдийд, хэнд хэлснийг ч нотолсонгүй, харин нийслэлийнхэн хэн хүнгүй л цувж, очиж байдаг "Гурван нуур" амралтын газар сүндэрлэн буй Чингисийн сүрлэг хөшөөг очиж үзээгүйгээ Ю.Цэдэнбалын "аянга цахилгааны ниргэлтээс" айснаас болсон гэжээ. Чингис хааныхаа нэр алдрыг хэнээс ч айж болгоомжлолгүй өндөрт өргөн, сайнаар бичиж ярьж байхыг шаардсан нэрт эрдэмтнийхээ санаа бодлыг хүндэтгэн үзэх ёстой ч аливаад тун гүнзгий нөлөө үзүүлдэг улс төрийн бодлого гэж айхтар зүйл бас байдаг гэдгийг нийтээр бараг ойлгох билээ.

Монголын ард түмний олон мянган жилийн түүхийн явцад тодорсон, ер бусын их хүн, дэлхийн түүхэнд гүнзгий ул мөрөө үлдээсэн, Монголчуудын удирдагч, эзэн богд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойн дуулиан жараад оны эхээр дахин нийтийн дунд түгэн, Монголын хүчирхэг төр, улсыг үндэслэгч Чингис хааныг төрүүлсэн ард түмэн нь болох монголчууд ч энэ ойд бэлтгэж байв. Монгол л хүн юм болохоор тэр үеийн нам, төрийн удирдагчид, их Эзэн Богдын ойг аятайхан тэмдэглэх гэж хирэндээ их анхаарал тавьж, Ю.Цэдэнбал даргалан Улс төрийн Товчооны хурлаар энэ тухай асуудлыг 5 удаа ажил хэрэгчээр ярилцаж, ой тэмдэглэх тогтоол төлөвлөгөө баталжээ. Ойг тэмдэглэх талаар Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга байсан Д.Төмөр-Очир ихээхэн анхаарал чармайлт тавьж байжээ. Ойн гол илтгэлийг түүхч эрдэмтэн Ш.Нацагдорж бэлтгэжээ. Мэдээж илтгэлийн талаар нам, засгийн удирдагч Ю.Цэдэнбал санал бодлоо хэлсэн бөгөөд түүний үзэл санаа нь аль аль талаа бодсон, хоёрдмол шинжтэй байсан бөгөөд тэрээр "Чингис бол монголын төрийн томоохон зүтгэлтэн, чадвартай жанжин, мөн монголын төрийн үндсийг тавьсан хүн болох нь маргаангүй. Харин тэгэхдээ Чингисийн харгис үйл ажиллагааг орхигдуулж болохгүй Чингис бол дэлхийн олон улсын ард түмэнд ихээхэн гамшиг зовлон учруулж, хүн төрөлхтний соёлд маш их хөнөөл хүргэсэн болохыг мартаж болохгүй" хэмээн зөвлөсөн бөгөөд тэр үед Ш.Нацагдорж таны хэлсэн санаа миний илтгэлд аль хэдийн тусгалаа олсон гэж баттайгаар хэлж байжээ. /Түүхийн хүрд, 1991.ХII сар, №1/

ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Ширэндэв "Чингисийн харгис тал, гэмт үйл ажиллагааг энд тэнд тарамдуулан хэлснийг нэг газар бөөгнөрүүлэн хэдэн чамбай үгээр сайн дүгнэх нь зүйтэй" гэж, Улс төрийн Товчооны бусад гишүүд ч иймэрхүү санал хэлжээ. Зөвлөлтийн элчингийн нөхөд илтгэлтэй танилцаад өгсөн саналын гол нь Чингисийн харгис талыг онцлон цохож тэмдэглэх хэрэгтэй байх гэжээ. Д.Төмөр-Очир "Москвагаас эрдэмтэн Майскийн бичсэн Чингисийн тухай өгүүллийг радиогоор хүлээж аваад байна.Үүнээс илтгэлдээ тусгах хэрэгтэй" гэдэг үүрэг өгсөн бөгөөд энэ нь бэлтгэгдсэн илтгэлийн гол санаатай яг адлхан зүйл байсан бололтой. /Түүхийн хүрд, 1991-12, №1/. Үүнээс үзэхэд нам, засгийн тэргүүн, ойг голлон зохион байгуулагч академийн ерөнхийлөгч, илтгэгч эрдэмтэн, Зөвлөлтийн судлаач, нөхдийн санаа үнэлэлт дүгнэлт ерөнхийдөө ойролцоо байжээ гэж хэлж болмоор.

Ийнхүү бүх бэлтгэл хангагдаж, Улс төрийн Товчооны шийдвэрийн дагуу Чингисийн төрсөн нутагт дурсгалын сүрлэг хөшөө босгож, "Чингис хаан" цуврал марк гарч, ном, өгүүллүүд олноор хэвлэгдэж, Чингисийн тухай баримтат кино монгол, орос, англи, хятад, франц хэл дээр тайлбартайгаар хийх шийдвэр гарч, ШУА-ийн шугамаар

олон эрдэмтэд, зочид, хөдөлмөрчид оролцсон ойн хурал болж, энэ нь монголчуудын сэтгэлд нийцэн, магнайгаа тэнийлгэцгээжээ.

Ойн арга хэмжээ удалгүй намжих тийш хандсан нь учир шалтгаантай байлаа. Академич Ш.Нацагдоржийн илтгэл нь ерийн л маягийн, ая тал бодсон шинжтэй зөөлөн илтгэл байв. Харин академич Ц.Дамдинсүрэн Чингис хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг бодитой үнэлэхийг зоригтой шаардсан үг хэлсэн нь олон нийтийн анхаарлыг их татжээ. Энэ үеийн улс төрийн уур амьсгалын талаар Зөвлөлтийн элчингийн ажилтан байсан хүн хожим бичсэнээс үзэхэд: "Ц.Дамдинсүрэнгийн үгийг Улаанбаатар дахь Зөвлөлтийн төлөөлөгчдийн орчин тойронд үндсэрхэх үзлийн үнэр шингэсэн мэтээр "аюултай" гэж үнэлсэн... Үнэхээр ч ой тэмдэглэх хөтөлбөрийг практик дээр хэрэгжүүлэх явцад НТХ-ы төлөвлөсөн санаа бодлын хэмжээнээс халин гарч, заримдаа илэрхий өдсөн өнгө аястай зүйл ч цухалзаж байв... Монголд тэмдэглэж байгаа Чингис хааны 800 жилийн ойн баяр ёслолын тухай Зөвлөлтийн зарим төлөөлөгчид Москвад өгсөн мэдээлэлдээ хийсэн үнэлэлт дүгнэлтдээ байдлыг хэт түгшүүртэй болгон, өнгө будгийг нь заримдаа дэндүү өтгөрүүлж, энэ ой улам бүр Оросын эсрэг чиглэлтэй болж байна гэж тэмдэглэж байсныг энд хэлэх хэрэгтэй. Энэ бүхэн мэдээжээр Москвад улс төрийн хувьд болгоомжлоход хүргэсэн нь гарцаагүй. Энэ бүхэн, бодвол, Ю.Цэдэнбалын даалгавараар Монголын удирдлага ойн арга хэмжээг хумих, төлөвлөсөн олон чухал, сонирхолтой зүйлүүдийг болиулах шийдвэр гаргахад нөлөөлсөн биз"<sup>2</sup> гэжээ.

Тэр үеийн Монголын удирдагчид Ю.Цэдэнбал, Д.Төмөр-Очир нарын сөргөлдөөний гол "алим" нь Чингисийн талаархи асуудал гэж үздэг хүмүүс байдаг ч ингэж хялбарчилж хандах нь учир дутагдалтай юм. Энэ хоёр зүтгэлтний маргаан мэтгэлцээний гол чиглэл өөр байсан юм. Д.Төмөр-Очир Чойбалсанг тахин шүтэхийн эсрэг явуулсан тэмцлийг улам хүчтэй болгох, ингэснээрээ Ю.Цэдэнбалын байр суурийг ганхуулах, түүнд арга барил хоцрогдсон, өөрийгөө шүтүүлэхийг оролдсон гэж зэмлэл тулгаж, шүүмжлэл өрнүүлжээ. Ю.Цэдэнбал нь Д.Төмөр-Очирыг ард түмний ололтыг үгүйсгэдэг, үндсэрхэг үзэл баримталдаг, үүний нэг илрэл нь Чингис хааныг тэнгэрт тултал өргөмжилж, тэр байлдан дагуулагчийг тахин шүтүүлэхийг оролдож, ингэснээрээ улс түмний хоорондын найрамдалд хор учруулсан, хамтран зүтгэгчидтэйгээ зан араншин тохирдоггүй, урьд нь ЗХУ-д нэгдэх санал гаргаж байснаа дараа нь нам, төрийн тухайн үеийн бодлогоос зөрж хятадтай ойртох гэсэн зэрэг ил далд зэмлэлийг түүнд тулгажээ. Урьд нь нэгийгээ дэмжин суга дэвшүүлж, аливаад гар нийлэн ажиллаж, хүн ёсоор сайхан үерхэж явсан тухайн үеийн Монголын улс төрийн хамгийн том хоёр зүтгэлтний хооронд ач тач зөрөлдөөн үүсч, энэ маргааныг Намын Төв Хорооны III бүгд хурал /1962/ нэг ёсоор шүүж, олонхийн дэмжлэгээр Ю.Цэдэнбал давжээ. Төмөр-Очирын үйл ажиллагаатай холбогдуулан Чингис хааны талаар Ю.Цэдэнбал, 1962, 1963 онд хоёр удаа дурдсанаас хойших энэ олон жилд эзэн богд Чингис хааны талаар хараан зүхэх нь бүү хэл албан ёсны илтгэл, өгүүлэл, ном хэвлэлд тэрээр юу ч бичиж яриагүй байна. Зарим хүний бичсэнчлэн аянга цахилгаан ч буусангүй, цуст яргачин гэж ч хараасангүй. Монголчууд ч найрамдал, нөхөрлөл, интернационализмын тугаа өндөрт "мандуулан", социализмын замаар "урагшилж", Чингисийн талаархи хүндэтгэлээ зөвхөн сэтгэлдээ тээж явав.

Академич Д.Төмөр-Очир тухайн цаг үедээ Чингис хааны үйл ажиллагааг дүгнэх талаар мөн л хашир болгоомжтой бодлого баримтлаж байсан бөгөөд монголын удирдагчид байсан олон жилийн турш Чингис хааны талаархи бодол санаагаа, үгүүлэл, илтгэл, албан ёсны баримт бичигт бичиж байсангүй. 800 жилийн ойн үеэр Москвад бэлтгэгдсэн сэдвийн агуулгыг илтгэлдээ тусгахыг тэрээр зааварчилж байжээ. Д.Төмөр-Очир ойн дараахан орон нутагт хэлсэн үгэндээ: "Саявтар монголын тулгар төрийг үндэслэгч Чингисийн төрсний 800 жилийн ойг тэмдэглэсэн билээ. Гэтэл үүнийг манай зарим хүмүүс хэтрүүлж урвуулан Чингис хааны байгуулсан феодалын төрийн ангийн чанарыг бүрхэгдүүлэн, түүний байлдан дагууллыг шагшин магтаж, ид хөөр болгох

<sup>2</sup> Ш.Г.Надилов. Ю.Цэдэнбал. 1984. –УБ., 1997. т. 33-34.

зэргээр марксизм-ленинизм ба пролетарийн интернационализмд харш үндсэрхэг үзэл цухалзуулж байсныг анхаарах хэрэгтэй юм. Үзэл суртлын ажилтан бид иймэрхүү бэртэгчин хойш татах үзэлтэй эвлэршгүй тэмцэж, засан залруулах, учрыг ойлгуулах ёстой<sup>3</sup> гэжээ. Энэ нь монголын хоёр удирдагч тухайн асуудлаар ойролцоо, бараг л усны дусал шиг адил бодлого баримталж байсныг нотолж байна.

Харин далаад оны дунд үед бичсэн хувийн тэмдэглэлдээ Ю.Цэдэнбал юм Чингис хааны тухай бичиж дурсахдаа: "Хасабе Шото-Японы генерал, Би 1937 онд Москва хүртэл буухиа галт тэргээр түүнтэй цуг явсан юм. Тэр япон хүн оросоор маш сайн ярьдаг байлаа. Чингис хаан япон хүн байсан. Солонгосын хагас арал ба Манжуураар дамжиж Монголд хүрээд Монголыг нэгтгэж, баруун зүг дайн хийхээр явсан юм гэж ярьж байв. Тэр таамаглалыг би няцаасан. Бид хоёр Москва хүртэл бүтэн долоо хоног энэ тухай л ярьж явлаа" /Гэрэл сүүдэр. т.99/ хэмээн бичсэнээс үзэхэд Ю.Цэдэнбал бүр залуу байхдаа домогт өвөг дээдэстээ өөриймсөг хандаж, Япон генералын санааг няцааж, бүтэн долоо хоног ярилцах мэдлэгтэй байсныг, хожим нь хэдийгээр магтан дуулж чадаагүй ч тэрээр дурсан санаж явсныг гэрчилж байна.

Коммунист, интернациональч үзэл хуваарьгүй ноёрхсон "социалист хатуу хэрмийн" дотор, үг хэлэх эрх, чөлөөт сэтгэлгээ сул хөгжсөн нөхцөлд, дэлхийн аугаа их хоёр том гүрний дунд, тэдний нөлөөнд байдаг, гадаад ертөнцөөс таслагдан оршдог бага буурай Монгол улсын төр, засгийн удирдлагууд олон жилийн турш Чингисийн ролийг үнэлэхдээ бүхэлд нь магтан дээдэлж чаддаггүй байсан нь гадаад учир шалтгаантай байв.

Чингис хаанд ихээхэн бодит, өөдрөг сэтгэлээр ханддаг байсан Энэтхэгийн удирдагч Ж.Неру өөрийн зохиолд: "1219 онд эхэлсэн тэр аян дайн Азиар барахгүй, Европыг шинэ аюулаар нөмөргөж, замдаа тааралдсан хот, тосгоныг арчин үгүй хийж, олон сая хүний амь насыг хөнөөн, Өрнө зүг үерийн ус мэт цутган оржээ. Хорезмыг үгүй хийв. Бухара хотыг олон сайхан орд харш, сая гаруй хүн ардынх нь хамт үнсэн товрог болгожээ. Нийслэл Самарканд хот эвдрэн сүйрч, түүний нэг сая оршин суугчаас дөнгөж 50000 хүн үлджээ. Герат, Балх зэрэг цэцэглэн хөгжиж байсан бусад олон хот устжээ. Сая сая хүн алагдсан байлаа. Олон зуун жилийн турш Дундад Азид цэцэглэн хөгжиж байсан бүх урлаг, гар урлал үгүй болж, Перс, Дундад Азийн соёл иргэншилт амьдрал яг л мөхсөн мэт болжээ. Тийнхүү Чингисийн явж өнгөрсөн бүх газар хоосон цөл мэт болж үлдсэн байна. /Ж.Неру. Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл. I дэвтэр. т.353/ гэжээ. Дундад Азиас гадна одоогийн Оросын өргөн уудам нутагт амьдарч байсан ард түмнүүдийн түүх шашдир, эрдэмтдийн ном бүтээлд иймэрхүү маягаар бичиж нотолсон баримт олон байдаг.

Дундад зууны үеийн байлдан дагуулагчид хэн нь ч гэсэн ялгаагүй л иймэрхүү түүх, намтартай байсан нь мэдээж. Гэхдээ Монголчууд бидний хувьд энэ баримтуудыг үгүйсгэх нотолгоо байхгүй болохоор асуудалд бодит ухаалаг сэтгэлгээгээр, тэр ард түмнийг энэрэн хайрлах, эрхийг нь, үндэсний ухамсарыг нь хүндэтгэх үүднээс хандах ёстой гэж үзэж байсан түүхт хүмүүсийг буруушаах нь хэр зохистой вэ? түүх мартагддаггүй, түүх хуучирдаггүй билээ. Эрт үеийн байлдан дагууллын төлөө одоогийн цөөн Монголчуудыг үзэн ядах үзэл бидний ойр хавьд, эргэн тойронд бий болбол үүнээс бид хожихгүй нь лавтай. Хуучин ЗХУ-ын төрийн албан ёсны үзэл бодол нь ч нэг хүний ролийг бодитой бишээр туйлшруулан үнэлэх явдлыг хүчтэй дургүйцэн буруушаадаг байсан нөхцөлд Оросын их ард түмэнд итгэн түшиглэдэг, "дуулгавартай дүү орон" Монголын удирдагчид Чингис хааныг магтан дуулж чадахгүй байсныг зөв ойлгон үзэж болох мэт.

Зөвлөлтийн дипломатч, казак үндэстэн Ш.Г.Надиров, Ю.Цэдэнбалтай хувийн талаар дотно харилцаатай, олон удаа уулзан ярилцаж, бас ч гэж бодол санааг нь тандан хүүрнэлдэж явсан ажээ. Тэрээр бичихдээ, "Ю.Цэдэнбал Чингис хааны нэр алдарт нэн хүндэтгэлтэй хандаж, түүний монгол овогтныг нэгтгэн, нэгдсэн хүчирхэг гүрэн

<sup>3</sup> Үнэн. 1990-02-24. №47.

байгуулахад гүйцэтгэсэн үүргийг өндөр үнэлдэг байв. Олон талын авъяас билэгтэй их хаанаараа бахархдагаа Цэдэнбал нуудаггүй байлаа. Чингисийн цуст байлдан дагуулалтын тухай яриа үүсэхэд тэрээр энэ нь эзлэгдсэн орны хувь заяанд сөрөг нөлөө үзүүлсэн гэдгийг үгүйсгэдэггүй авч “цаг үе нь тийм харгис хатуу байсан юм чинь” гэдэг байв... Цэдэнбал монголын түүхийн шинжлэх ухаанд зөвлөлтийн түүхчдийн тулган хүлээлгэсэн албан ёсны үзлээс огт өөр үзэл бодолтой байсан юм” гэж хэлснээс үзэхэд Ю.Цэдэнбал улс төрийн бодлоготны хувьд их хааныг тэнгэрт тултал туйлшруулан магтаад байгаагүй ч, дотоод сэтгэлдээ дотно сайнаар хандаж байжээ.

Ерээд оны Монголын гадаад, дотоод байдалд үндсэн өөрчлөлт гарч, аль нэг улсаас шууд хамааралт байдал өөр болж, нэг үзэл суртал, нэг намын бодлогод баригдах явдал суларсантай холбогдон эзэн Богд Чингис хааны тухай судлагаа өргөжиж, түүний үйл ажиллагааг олон ургальч үзлийн үүднээс дүгнэн цэгнэх эрх чөлөө бодитой хэрэгжих болов. Ийм нөхцөлд Чингис хааны мэндэлсний ойг 1992 онд тэмдэглэсэн юм. Суут эзэн Богд Чингис хааны түмэн өлзий гийсний 830 сүүдэр тухайлсны их ойн хүндэтгэлийн ажиллагаа төрийн ордны Их Хурлын танхимд болж, монголын төр, засгийн удирдагчид хэлэхдээ: Чингис хаан бол монголын төрийг эмхлэн байгуулагч, төрийн гарамгай зүтгэлтэн, монгол овогтны суут хүү, төр ёсны цагыг эзэлсэн ухаант мэргэн, тэнгэрлэг их эзэн, Төв Азийн нүүдэлчдийн соёл иргэншлийн мөнхийн зул, Монгол улсын цаглашгүй ноён нуруу, эгнэшгүй хүлэг баатар, цэргийн суут жанжин, чин журамтан, хүн төрөлхтний гаргуун суу билэгтний нэг, түмэн олны нандин шүтээн, Богд эзэн, тэнгэр язгуурт онгон сахиус, нийт монгол үндэстний баатар<sup>4</sup> хэмээн үнэлэн дүгнэхийн хамт Монгол улсын Ерөнхийлөгч маань үнэнийг эрхэмлэх монгол түмнийхээ төв төвшин, голч сэтгэлийг илэрхийлж: “бусад орныг эзлэх аян дайны хөлд янз бүрийн улс түмэн багагүй хохирон сүйрсэн явдал бий. Түүнийг бид үгүйсгэх, тэр тусмаа сайшаах ч учиргүй, сөрөг бурангуй явдал байв гэж үзсээр ирсэн”<sup>5</sup> хэмээсэн юм.

Дэлхийд хосгүй их үйлсийг бүтээсэн, суут жанжин Чингис хаан хүн л юм болохоор алдаа эндэгдэл ч гаргаж, гавъяат үйлс ч бүтээжээ. Нэг хэсэг нь түүнийг сөрөг талаас нь бичиж ярьж ирсэн ч цаг цагаараа байдаггүй гэгчээр энэ түүхт хүний ер бусын чанарын тухай магтан хэлэлцэх нь давамгайлах болсон юм. Түүний тухай дэлхийд нэрд гарсан нийгмийн зүтгэлтэн, цэргийн жанжин, эрдэмтэд хэлэхдээ: “Гайхамшгийн их жолоодогч Чингисийн цэргийн жанжны гайхамшигт урлагийн хүчээр тэд ийнхүү ялалт байгуулж чадсан. Чингис бол түүхэнд гарсан цэргийн суут ухаантан, жолоодогч эргэлзээгүй мөн. Түүний дэргэд Македоны Александр, Цезарь хоёр юу ч биш мэт... Дээд зэргийн авъяаслаг зохион байгуулагч, авъяаслаг сайдуудыг биедээ татаж, тусламжийг нь авч чаддаг ухаалаг хүн байжээ... Энэ хүн миний сэтгэлийг уяраав. Нүүдэлчин аймгийн харгис хэрцгий, догшин феодалын удирдагч хүн над мэтийн хот газрын, феодалын ёсны юм бүхнийг үзэн яддаг, хүчирхийлэх явдлыг эсэргүүцдэг, зөөлөн дөлгөөн хүний сэтгэлийг уяраана гэдэг гайхалтай биш үү” /Ж.Неру/; “Хэрэв М.Александр Чингисийн үед амьдарч байсан бол Чингист шавь орж, түүний жанжны эрдэм ухаанд хичээнгүйлэн суралцах байсан” /Джувейн/; “Чингис хэзээ ч ялагдаж байгаагүй харин би дарагдахыг үзэж байсан” /Наполеон/; “Сталин үнэнхүү цуутай этгээд юм. Сталины шүтээн бол Чингис хаан болон тиймэрхүү аугаа хүмүүс”, “тэд өрхийн засаглалыг хүчтэй дэлгэрүүлж байсан. Тэгээд Аричууд бид монголчуудыг гүнээ хүндэтгэдэг” А.Гитлер; “Чингис хаантай эн зэрэгцэх баатар дэлхийд гараагүй” /Японд хэвлэгдсэн “Дэлхийн түүх”/; “Чингис хаан эрүүл саруул ухаантай, хүний үгийг сайн анхааран сонсдог, нөхөрсөг, шулуун шудрага, догшин ширүүн атлаа уужим сэтгэлтэй хүн байсан”. /Францын Рене Груссе/; “Чингис хааны удирдсан Монголчуудын довтолгоо тал бүртээ цацрах галын дөл адил үйл явдал байсан” /Арабын Ибн-аль-асар/; “Монгол орон Чингис, хааны орон гэрт үхэшгүй алдрыг олж авсан... Чингис хаан чийрэг чадалтай, асар эрэмгий, суут ухаантай, хатуу ширүүн, баатар шударгуу, зориг чанга гэх зэргээр мусульманы ертөнц Чингисээс сүрдэн айж, гайхан

<sup>4</sup> Ардын эрх, 1992-05-19, № 66.

<sup>5</sup> Мөн тэнд



биширч байсан" /Английн Саундерс/; "Чингис хаан бол дэлхийн түүхийн хамгийн том хүмүүсийн нэг" /Германы Краузе/; "Бид Македоны Александраас эхлэн Цезариар үргэлжлүүлэн Наполеоноор дууссан гарамгай хүмүүсийн үйл явдлыг судалж байв. Тэдгээр жүжигтэй харьцуулахад /Чингис/ илүү аварга том юм. Ер нь Чингисийн амьдрал нь энгийн хүмүүстэй жишин хэлэхийн аргагүй юм". /Английн Ф.Фокс/; "Сүүлийн мянган жилийн хамгийн сод хүн, төр, цэргийн зүтгэлтэн нь Чингис хаан" /Вашингтон пост/; "Чингис хаан орчин үеийн дэлхийг төвхнүүлэгч" /Джон Макалистер.АНУ/ гэж сайнаар бичсэн үнэлсэн зүйл мөн л тоолох аргагүй олон тааралдах боллоо.

Орос, Зөвлөлтийн эрдэмтэн судлаачдын бичсэн зүйлд ч Чингисийн ролийг нэг талаас нь хараар будахаас ямар нэгэн хэмжээгээр ангижирч, бодитойгоор хандах хандлага бий болжээ гэж үзэж болох юм. Жишээ нь: "Москвагийн аугаа их болсон нь Монголын хаадын хүчинд дулдуйджээ". /Карамзин/; "Оросыг нэгтгэхэд Монголын хаадын бодлого үлэмж нөлөөтэй байсан" /Ф.О.Ключевский/; "Москвагийн төр улс Алтан ордны үлдэгдэлд тулгуурлаж үүссэн болохоор Киевийн Русийн биш, Чингисийн их гүрний удам залгамжлагч юм" /Эренжен Хара Даван/; "Чингис хаан-тэр үеийн олонхи улс түмний амьдралд гүнзгий өөрчлөлт оруулсан юм. Чингис хаан стратегич, тактикчийн хувьд урьд өмнө үеийн хүмүүсээсээ хавьгүй давсан төдийгүй, өөрийнхөө зуунаас үлэмж түрүүлсэн юм. Олон улсын мөргөлдөөнийг дайны замаар шийдвэрлэж байгаа цагт түүний нэр бүх дэлхийн гарамгай жанжуудын нэрийн дотор хурц тод байх болно." /Г.Е.Грумм Гржимайло/; "Нэгэнтээ ингэж задрааж хаячихсан нийгмийг эмхэлж байранд оруулна гэдэг тун хэцүү ... ганцхан Чингис л хэрэгтэй. Хатуу гартай, угаасаа ухаалаг, уян хатан бодлоготой төрийн том жолоодогч л хэрэгтэй болоод байна" /М.Капица/; "Монголын байлдан дагуулал нь тооны давуугаар нухчин дарж байсан үй түмэн цэргийн эмх замбараагүй уулгалсан дайралт байгаагүй. Монголын цэргүүд тусгай, тодорхой стратегийн төлөвлөгөөний дагуу байлдаж, замдаа тохиолдох соёлт ард түмний илүү олон тоотой цэргийг бут цохиж байлаа. Ийм олон хэсгээс бүрдсэн их гүрнийг хадгалах гэдэг үүнээс ч бэрх байсан бөгөөд ... их гүрний нэгдэл нягтралыг Чингис хааны үе төдийгүй түүний хөвгүүд, ач нарын үед ч сахин хадгалж чадсан юм." /В.В.Бартольд/; "Чингис цэргийн туршлагатай чадварлаг жолоодогч байсан төдийгүй гайхамшигт стратегич, арми, тусгай цэргийн бүлгийн томоохон байлдаан тулааны удирдагч байлаа" /Б.Я.Владимирцов/; "Оросыг монголчууд байлдан түрэмгийлсэн нь Москваг тойрон нэгдэж, булаан эзлэгчидтэй тэмцэхэд тархай бутархай Оросын ард түмнийг нэгтгэх, Орос дахь Монголын хаант улсыг унасны дараагаар нэгдмэл хүчирхэг улс болоход дөхөм болсон" /А.П.Окладников/; "Дэлхийн түүхэнд хамгийн алдартай түүхэн бие хүн, байлдан дагуулалтаараа олон улсын түүхэнд томоохон байр суурь эзэлдэг цэргийн гарамгай жанжин Чингис хааныг төрүүлсэн ард түмэн түүгээрээ бахархах нь зүй ёсны асуудал мөн" /С.К.Роцин/ гэж хэлж, ярьж, бичих болсон нь Монголчууд бид Чингис хааны тухай, түүний түүхэнд гүйцэтгэсэн үүргийг үнэлэх өөрийн бодол санааг ил тодоор бичиж ярих гадаад аятай нэг нөхцөл бүрдүүлсэн юм.

Түүхэн ёсоор бүрэлдэн буй болсон чөлөөт сэтгэлгээний одоогийн нөхцөлд Чингис хаан судлалыг хөгжүүлэх нь эх орныхоо буурал түүх, соёл, аугаа их өвөг дээдсийн намтар түүхэнд ухаалгаар, хүндэтгэлтэй ханддаг, эх оронч, үндэс угсаагаа гэх үзэл хүмүүжлийг иргэд, залуу үедээ төлөвшүүлэхэд нь нэн чухал ач тустай билээ. Үүнтэй холбогдуулан зарим санал дэвшүүлж байна. Үүнд:

1. Дэлхийн түүхчид, улс төрчид, цэргийнхний анхаарлыг олон жил татсаар ирсэн Чингис хаан судлалын асуудлаар судалгааны тусгай төвийг МУИС-д байгуулж, түүний ажилд энэ чиглэлээр ажилладаг эрдэмтэд, ялангуяа авъяаслаг оюутнуудыг өргөн оролцуулах, Чингис судлалаар мэргэшүүлэх, гадаад, дотоодод судалгаа, сурталчилгаа явуулах нь манай их сургуулийн нэр хүнд, түүхийн сургалтын чанарыг дээшлүүлэхэд, оюутны хүмүүжилд сайнаар нөлөөлнө гэж бодож байна.
2. Манай оронд түүхийн боловсролын асуудалд бага анхаарч буй одоогийн нөхцөл байдлыг өөрчлөх зорилгоор түүхийн боловсрол, шинжлэх ухааны манайдаа эртний төв болохын хувьд нь, монголын үндэсний шинжтэй хамгийн том эрдмийн уурхай

болохын хувьд нь МУИС-д Түүхийн факультет байгуулах цаг нэгэнт болжээ. Нийгэмд түүхийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүргийг олон нийтэд ойлгуулах, түүхийн мэргэжлийн нэр хүндийг өндөржүүлэх, түүхийн боловсролын чанарыг сайжруулах, түүхийн салбарын тэнхмүүдийн ажлын уялдааг бэхжүүлэх, суралцагчдын соёл, эх оронч хүмүүжлийн ажлыг идэвхжүүлэх, түүхийн салбарын гадаад харилцааг цаашид өргөтгөх, түүхийн багш нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх тогтвортой систем бий болгох талаар факультетын үүрэг их байх юм.

3. Чингис хааны амьдрал, үйл ажиллагааны сэдвээр /доод тал нь 8 цагийн/ тусгай курс нээж оюутан залуус, ялангуяа гадаадын оюутнуудыг өргөнөөр оролцуулах нь сонин, үр дүнтэй ажил болно.
4. Жар гаруй жилийн түүхтэй ууган их сургууль-МУИС-д Монголын түүх судлалын тусгай тэнхим эсвэл төв сэргээн байгуулах хэрэгтэй байна. Мэргэжлийн болон нийт салбаруудад үздэг Монголын түүх хичээлийн судлах цагийг боломжоор нэмэгдүүлэхээс эхлээд /одоо Монголын 800 мянган жилийн түүхийг судлахад 36 цаг өгч буй нь сургалтын чанарт таагүй нөлөөлдөг/ БСШУЯ ба ШУА-ийн эрдэмтэдтэй хамтрах замаар манайд байдаг 100 гаруй их, дээд сургууль, коллежийн Монголын түүхийн багш нартай хамтран ажиллах, эрдэм шинжилгээ, арга зүйн зөвлөлгөө өгдөг, мэргэжлийг нь дээшлүүлдэг жинхэнэ төв болгох, энэ ажлын менежментийг боловсруулах талаархи олон талтай ажилдаа багш нарынхаа мэдлэг, туршлага, бололцоог улам дайчлан ашиглах хэрэгтэй байгаа юм.
5. Түүхийн шинжлэх ухааны намтар судлалын салбарт мэргэжиж буй багш нар, МУИС-д олон байгаад тулгуурлан манай сургуульд үндэсний намтар судлалын төв байгуулах бололцоо байна. Үүнд Чингис судлалыг дорвитой байр эзлүүлэх, бусад түүхэн зүтгэлтнүүдийн үйл ажиллагааг чиг зорилготойгоор судлах, энэ ажилд оюутнуудыг өргөн оролцуулах, энэ чиглэлээр гадаад, дотоодын төсөл, санхүүжилт олох боломж ч байж болох билээ. Товчхонд хэлэхэд Чингис судлал, Монголын түүх, Түүхийн шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх талаар хийх ажил нилээд байна.

### **About the who and how evaluated the Chinggis khaan Summary**

*By Ts. Jambalsuren*

The historians, scholars, politicians from medieval times evaluate differently the role of Chinggis khaan. The author made an review of the evaluation of role of Chinggis Khaan in XX century and an impact of the ideology on it.